

ЭРДЭНЭ РЕСУРС “УЛААН” АЛТНЫ ШИНЭ НЭЭЛТИЙГ ТЭЛЛЭЭ **Нээлтийн цооногоос хойд зүгт 50 метрт 1.1 г/т алтны агуулга** **бүхий 217 метрийн цооногт 3.5 г/т алтны агуулга бүхий 53 метрийн** **интервал огтлов.**

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот
2021.09.23

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Баян Хөндий алтны ордоос баруун зүгт 300 метрт орших Улаан алтны нээлтийн нэмэлт өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг танилцуулахад таатай байна. Энэхүү хэвлэлийн мэдээнд нийт 1,803 метрийн таван (5) цооногийн үр дүнг танилцуулсан. 4-р улирлын эхэнд үлдсэн цооногуудын үр дүнг танилцуулна.

Онцлох мэдээлэл

- Хөндий Алтны Дүүрэгт өнөөг хүртэл хамгийн зузаан эрдэсжилт бүхий интервалыг огтолсон нь өндөр агуулга бүхий интервалыг агуулж байв:
 - UDH-14: 1.07 г/т алтны агуулга бүхий 216.6 метр
 - 3.55 г/т алтны агуулга бүхий 53 метрийн интервалд 19.58 г/т алтны агуулга бүхий 5 метрийн интервал багтаж байна
 - Цооног 404.6 метрт алтны эрдэсжилтээр төгссөн
 - UDH-15: 0.79 г/т алтны агуулга бүхий 363.2 метр
 - 1.98 г/т алтны агуулга бүхий 91 метрийн интервалд 7.29 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал багтаж байна
 - Цооног 461.3 метрт алтны эрдэсжилтээр төгссөн
 - UDH-16: 0.59 г /т алтны агуулга бүхий 119 метр
 - UDH-17: 2.26 г/т алтны агуулга бүхий 36.3 метр
 - Цооног 350.3 метрт 21.6 г/т алтны агуулга бүхий 2.3 метрийн интервалаар төгссөн
- Улаан талбайн шинэ нээлт нь бүх зүгт болон гүнд тэлэх боломжтой хэвээр байна.
 - Нийт 1,401 метрийн дөрвөн (4) цооногийн үр дүнг 4-р улирлын эхэнд танилцуулна.

Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Улаан хэтийн төлөв бүхий талбайг Хөндий Алтны Дүүргийн томоохон алтны нээлт гэдгийг баталлаа. Баян Хөндий алтны ордоос 300 метрт орших энэхүү талбайд 10 г/т-оос өндөр хэд хэдэн интервалууд болон эрдэсжилтийн маш өргөн бүсүүдийг 200 метрийн гүн хүртэл огтолсон нь Улаан хэтийн төлөв бүхий талбайн цар хүрээг илэрхийлнэ. Улаан талбайн алтны эрдэсжилт нь бүх зүг рүү нээлттэй бөгөөд нээлтийн баруун зүгт хэд хэдэн хөрсний болон геофизикийн аномаль нь шалгагдаагүй хэвээр байна.”

“Улаан болон Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдлөгийн хөтөлбөр үргэлжилж байгаа бөгөөд 4-р улиралд үр дүнг танилцуулахаар төлөвлөсөн. Улаан талбайд тодорхойлсон томоохон алтны бүс, Хар Морь талбайн нээлт, Баян Хөндий ордын нөөц, Алтан Нар ордын нөөц зэргээс харахад Хөндий Алтны Дүүрэгт дэлхийн хэмжээний нээлт хийх боломжтой хэмээх бидний таамгийг баталж байна.”

Өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүн

Энэхүү танилцуулж буй Улаан талбайн өрөмдлөгийн хөтөлбөр нь 2021 оны 8 сарын 11-нд мэдээлсэн (хэвлэлийн мэдээтэй танилцана уу) нээлтийн цооногуудын эргэн тойронд эрдэсжилт хэрхэн үргэлжилж байгааг тодорхойлох зорилготой байсан. Хөтөлбөр нь 3,204 метрийн турш есөн (9) цооногоос бүрдсэн. Цооногууд нь хоорондоо 25-50 метрийн зайтай бөгөөд хамгийн гүндээ 461 метр байсан бөгөөд 1.2 км² талбайг судалсан.

Энэхүү хэвлэлийн мэдээнд нийт 1,803 метрийн таван (5) цооногийн (UDH-14 to UDH-18) үр дүнг танилцуулав. Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох мэдээллийг Хүснэгт 1-т харуулсан ба өрөмдлөгийн хөтөлбөрийн план зураглал ба хөндлөн зүсэлтийн зургуудтай хавсралтаас танилцана уу.

Хүснэгт 1: Улаан 2021 3-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох үр дүн

Цооног	М-ээс	М хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т алт
UDH-14	106	117	11	3.68
Түүнд	110	111	1	36.58
Ба	188	404.6 ⁽²⁾	216.6	1.07
Түүнд	192	245	53	3.55
Түүнд	202	207	5	19.58 ⁽³⁾
Түүнд	208	209	1	16.75
UDH-15	60	63	3	0.41
Ба	97	461.3 ⁽²⁾	364.3	0.79
Түүнд	124	215	91	1.98
Түүнд	130	140	10	7.29
Түүнд	130	131	1	15.13
Түүнд	138	139	1	49.36
Түүнд	214	215	1	10.47
UDH-16	65	184	119	0.59

Цооног	М-ээс	М хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т алт
Түүнд	117	120	3	4.52
Түүнд	119	120	1	11.91
Ба	212	226	14	0.44
UDH-17	287	289	2	1.71
Ба	314	350.3 ⁽²⁾	36.3	2.18
Түүнд	344	350.3	6.3	8.59
Түүнд	348	350.3	2.3	21.57
UDH-18	4	6	2	0.51
Ба	142	146	4	0.45
Ба	263	279	16	0.32
Ба	300	308	8	0.65
Ба	346	350.3 ⁽²⁾	4.3	0.49

1. Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.
2. Цооногийн төгсгөл
3. Таван цооногийн нэг метрийн интервалууд нь тус бүр 10 г/т алтны агуулгаас өндөр агуулга огтолсон, үүнд 15.53-аас 21.76 г/т алтны агуулга багтаж байна.

Улаан дахь алтны эрдэсжилт нь газрын гадаргаас 100 метрийн гүнээс эхэлдэг бөгөөд Улаан тусгай зөвшөөрлийн зүүн зүгт орших Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрөл дэх Баян Хөндий эпитеpmаль алтны ордыг агуулагч цагаан гялтгануураар хувирсан лафилли туфын нэгжид агуулагдаж байна. Алтны агуулга нь агуулагч туфыг огтолсон кварц ± гематит судлуудтай холбоотой 0.1 г/т-оос 49.4 г/т алтны агуулгын хооронд байна. Улаан талбайд кварцын судлын хоёр чиглэл байдаг. Хэдийгээр энэхүү хоёр судлууд нь тус бүр эрдэсжсэн боловч анизотропийг тодорхойлохын тулд нэмэлт хайгуул, судалгаа хийгдэж байна. Алтны эрдэсжилт нь литологи болон структурын хувирлаар хянагддаг хэмээн үзэж байна. Хамгийн өндөр агуулгатай алтны эрдэсжилт нь эпитеpmаль маягаар зүсэгдсэн адуляр ба цагаан гялтгануурын хувирал, жигд бус кварц-гематит, кварц-адуляр, кварц-цагаан гялтгануурын судлууд болон кварц-хлорит-магнетит судлуудтай хослон тархсан цахиуржилтын үеүдэд тохиолддог. Ихэнх тохиолдолд эдгээр судлууд дотор нүдэнд үзэгдэх алт илэрсэн.

Улаан алтны нээлтийг багтаасан талбайд соронзон болон диполь-диполь туйлшралын геофизикийн судалгааг хийсэн. Эдгээр геофизикийн өгөгдлийн багцын боловсруулалт, тайлал нь бага соронзон тэмдэглэл болон тайлал хийсэн хувирсан лапилли туф нэгжийн хооронд хүчтэй хамаарал байгааг илэрхийлж байна. IP эсэргүүцэл нь UDH-10, UDH-14, UDH-15 ба UDH-16 цооногуудад агуулагдах өндөр агуулга бүхий интервал болон эсэргүүцлийн өндөр өгөгдөлтэй хүчтэй хамааралтай. Алтны эрдэсжилттэй холбоотой геофизикийн хамаарлыг Улаан талбайн өмнөд хэсэгт хийх ирээдүйн судалгаанд ашиглах болно.

Эрдэнэ Ресурс нь 2020 оны 12 сард Улаан тусгай зөвшөөрлийн 49 хувийг авснаас хойш хайгуулын үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрлийн зүүн өмнөд хэсэгт төвлөрч байна. Эрдэнэ Ресурс нь тусгай зөвшөөрлийн талбайн зүүн хэсэгт орших Вестгейт зэрэг судалгаа хийгдээгүй хэд хэдэн хэтийн төлөв бүхий зорилтот бүсүүдийг

тодорхойлсон. Вестгейт бүсэд Хар Морь талбайн эрдэсжилтийн өргөтгөл байх боломжтойг хөрсний дээжлэлтээр тогтоосон. Түүнээс гадна, Эрдэнэ Ресурс нь Улаан тусгай зөвшөөрлийн хойд хэсэгт хийсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр турмалин брекчийн бүсэд аномаль алт болон зэс огтолсон.

Компанийн 100% эзэмшдэг Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай болон түүнтэй зэргэлдээ орших Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь нийтдээ 4,350 га талбайг хамардаг бөгөөд Улаан-Хөндий гидротермаль хувирлын бүс нь филлик, аргил болон цахиурын хувирлаар тодорхойлогддог. Улаан - Хөндий хувирлын ул мөрөөр Эрдэнэ Ресурс нь хэд хэдэн өндөр ач холбогдол бүхий хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон бөгөөд үүнд Баян Хөндий эпитеpmаль алтны орд, Хар Морь эпитеpmаль алтны хэтийн төлөв бүхий талбай болон өмнөд Улаан нээлт зэрэг багтаж байна. Эрдэнэ Ресурс нь Хөндий - Улаан хувирлын бүсийг хайгуул хязгаарлагдмал хийгдсэн, дэлхийн хэмжээний алтны ордыг агуулах томоохон гидротермаль систем байх боломжтой гэж үзэж байна.

Улаан нээлтийн өмнөд хойд бүс, Вестгейт, Хар Морь хэтийн төлөв бүхий талбайд нэмэлт өрөмдлөгүүд хийгдэж, 4-р улирлын дундуур үр дүнг танилцуулахаар төлөвлөж байна.

Улаан тусгай зөвшөөрлийн талбай

Эрдэнэ Ресурс нь 2020 оны 12-р сард Улаан тусгай зөвшөөрлийн 49%-ийг худалдан авснаар 100% эзэмших болсон. Компани нь Баян Хөндий алтны ордын нээлтийн дараа 2017 онд Улаан тусгай зөвшөөрлийн 51%-ийг худалдан авсан.

Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь томоохон хувирлын бүсийн зүүн өмнө зүгт байрладаг ба энэхүү хувирлын бүс нь зүүн хойш чиглэн 10 км үргэлжилдэг. Энэхүү хувирлын тренд нь Баян Хөндий алтны ордыг агуулагч цагаан гялтгануур, серицитийн гадна бүс болон серицитийн хувирлын захаар хүрээлүүлсэн хүчтэй хоёрдогч цахиурын төв бүсийг агуулдаг. Энэхүү зүүн өмнөд трендийн дагуу хувирсан бүсэд Улаан, Баян Хөндий болон бусад эрдэсжсэн хэтийн төлөв бүхий талбай (Хар Морь ба Алтан Сум талбай) багтаж байгаа нь зүүн өмнөд трендийн хагарлын дагуу бүс нутгийн структурын тэлэлтийн тэгш бус байдал ба томоохон галт уул - плутоник төвтэй холбогддог. Улаан тусгай зөвшөөрлийн талбай дахь хэтийн төлөв бүхий болон зэргэлдээ орших бүсүүдийн эрдэсжилт, хувирлууд нь томоохон структурын дагуу давхцаж эсвэл сунаж эрдэсжсэн нуман шилжилт бүхий баялаг магмын арлын нуман хувиралтай уялддаг.

Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь Баян Хөндий алтны ордоос баруун зүгт 350 метрт төрийн өмчит Эрдэнэс Алт Ресурс ХХК-ийн эзэмшдэг Хүрэн Цав тусгай зөвшөөрлөөр тусгаарлагдан, 1,780 га талбайг хамран оршдог. 2021 оны эхээр Эрдэнэс Алт Ресурс ХХК нь Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий болон Улаан тусгай зөвшөөрөлтэй зэрэгцээ орших бүсэд өрөмдлөгийн болон геологийн судалгааг хийх тухай мэдэгдсэн.

Анхан шатны өрөмдлөгөөр огтолсон алтны эрдэсжилтийн өргөн бүс, хиймэл дагуулын зураглал, геофизикийн судалгаа болон гадаргуун хувирал зэргийг үндэслэн Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий алтны ордыг агуулагч гидротермаль систем нь Баян Хөндий ордоос баруун-баруун өмнөд бүсэд тэлж, Хүрэн Цав тусгай зөвшөөрлийн талбайн хойд хэсгээр дайрч, Эрдэнэ Ресурсийн Улаан тусгай зөвшөөрлийн талбайн өмнө зүгт үргэлжлэн тэлж байна хэмээн үзэж байна. Хүрэн Цав тусгай зөвшөөрлийн талбайн хойд өнцөг нь гурвалжин хэлбэртэй бөгөөд Баян Хөндий, Улаан тусгай зөвшөөрлийн талбайн урд хэсгийг тусгаарлан оршдог. Эрдэнэ Ресурс нь Эрдэнэс Алт Ресурс ХХКомпанитай байнгын харилцаатай ба техникийн мэдээллийг хуваалцах, оролцогч талуудын өгөөжийг нэмэгдүүлж, тусгай зөвшөөрлүүдийн талбайн хөгжүүлэлтийн хүрээнд хамтарч ажиллах боломжуудыг судлах болно.

Улаан тусгай зөвшөөрлийн талбайн хойд хэсэг нь Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн баруун хил залгаа оршдог бөгөөд геологи, хувирал болон гадаргуун эрдэсжилтийн анхан шатны судалгаан дээр тулгуурлан Хар Морийн эрдэсжилтийн баруун зүг дэх тэлэлтийг агуулах боломжтой хэмээн үзэж байна.

Хөндий алтны дүүрэг

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Баян Хөндийд 2.19 г/т дундаж алтны агуулга бүхий 585,100 унц баттай болон бодитой геологийн нөөц¹ (“Measured and Indicated Resources”)², 2.18 г/т алтны агуулга бүхий 35,900 унц боломжит нөөц (“Inferred Resources”)³ тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7 г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтдаг. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7-р сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба

¹ Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2021 оны 8 сарын 16-нд танилцуулсан 2021 оны 2-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангийн хэвлэлийн мэдээнээс танилцана уу.

² Баттай & Бодитой геологийн нөөц: 2.39 г/т алтны агуулга бүхий 232,700 унц баттай, 2.08 г/т алтны агуулга бүхий 352,400 унц бодитой нөөц

³ Батлагдсан & Магадласан: 4.4 г/т алтны агуулга бүхий 165,000 унц батлагдсан, 3.4 г/т алтны агуулга бүхий 256,000 унц магадласан үйлдвэрлэлийн нөөц; Үйлдвэрлэлийн нөөцийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хөндий Алтны Төсөл NI 43-101 Техникийн Тайлан, Tetra Tech 2019 оны 12 сарын 4-нд SEDAR болон компанийн вебсайт дээрх мэдээлэлтэй танилцана уу.

дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор боловсруулахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2023 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geol, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс ("SGS") лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт ("QA/QC")-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмит спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 гр дээжний 75 микроноос бага байх 30 гр бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцганд үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь

2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнэ Ресурсийн ложистикийн гэрээт Монруд ХХК гүйцэтгэдэг.

Тайлагнасан интервал нь бодит зузаан бөгөөд өөрөөр хэлбэл цооногийн өргөн юм. Улаан талбайн өрөмдлөгийн цооногуудыг 85 градусын уналаар өрөмдсөн ба алт агуулсан судлын баруун-хойд баруун трендийн дагуу баруун урд уналын дагуу чиглэсэн. Бодит өргөнийг баталгаажуулахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Интервалуудын тайлагнасан агуулга нь түүвэр интервалын уртад үндэслэсэн жигнэсэн дундаж үзүүлэлтүүд юм. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч 10 г/т алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>


Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>


ULAAN DRILLING CONFIRMS NEW DISCOVERY IN KHUNDII GOLD DISTRICT

Khundii – Ulaan Tenements, BK Deposit and Prospects Location Map

Khundii – Ulaan Active Discoveries and Prospects




Khundii – Ulaan Hydrothermal Alteration Footprint





ULAAN GOLD DISCOVERY – 300 METRES WEST OF BAYAN KHUNDII DEPOSIT

Bayan Khundii Gold Trend Continuation and Ulaan Gold Discovery



ULAAN SECTION A – LOOKING WEST

Highlighted Gold Mineralized Intervals



SE ULAAN PROJECT AREA